

**СҮХБААТАР АЙМГИЙН ТӨВ БАРУУН УРТ ХОТОД БАРИГДАХ 20 ГКАЛ/Ц ХҮЧИН  
ЧАДАЛТАЙ ДУЛААНЫ СТАНЦ, БАРЬЖ АШИГЛАХ ТӨСЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ  
МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН**

/АЖ АХУЙН НЭГЖИЙН РЕГИСТРИЙН ДУГААР: 5638089/

**ХЯНАСАН:**

СҮХБААТАР АЙМГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН,  
АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН МЭРГЭЖИЛТЭН

.....

**ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮҮРЭГ ХҮЛЭЭСЭН:**

“БЬЮКСАН ИНЖЕНЕРИНГ”

компаний захирал

ЧОЙ САНГ

**БИЕЛЭЛТИЙГ ТАЙЛАГНАСАН:**

“БЬЮКСАН ИНЖЕНЕРИНГ” компанийн

ХАБЭАБО хариуцсан менежер

А.АНДБАЯР

## ТӨСЛИЙН ҮЕ ШАТНЫ ХЭРЭГЖИЛТИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Сүхбаатар аймгийн Баруун Урт хотод баригдах 20 Гкал/ц хүчин чадалтай дулааны станц, барьж ашиглах төслийг “Мон Энержи Корпораци” ХХК компани гүйцэтгэж байна.

Сүхбаатар аймгийн дулаан хангамжийг сайжруулах төслийн ажлын гүйцэтгэгч “МонЭнержи Корпораци” ХХК нь төслийн талбайд 2023.04 сард эхэлсэн бөгөөд өнгөрсөн хугацаанд доорх ажлуудыг гүйцэтгээд байна.

2023 оны 05 -р сараас барилгын суурийн ажил, конвейер I, II, бутлуурын барилгын суурийн ажлууд эхэлсэн.

Конвейер I, II , бутлуурын барилга, харуулын байрны суурь, түлш хүлээн авах барилга, утаа сорогчийн барилгын суурь, цахилгааны барилгын суурь зэрэг үндсэн барилга угсралтын ажил 30 хувийн гүйцэтгэлтэй байна.

Зуух угсралтын ажил нь 2023 оны 04 -р сарын 10 -нд эхэлсэн. Одоогийн байдлаар зуух 1,2,3-ын экран хоолой, циклон, эканомайзер, агаар халаагч зэрэг тоноглолуудыг угсарч дуусаад байна.

2023 онд төслийн гүйцэтгэл

Барилга угсралт 30 %

Зураг төсөв 70 %

Тоног төхөөрөмж ханган нийлүүлэлт 60 %

Нийт гүйцэтгэл 44 % тай явж байна.

2023 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд “ МонЭнержи Корпораци ” ХХК-ийн зүгээс доорх үндсэн чиглэлийг голлон хэрэгжүүлэн ажиллалаа.

- Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний хүрээнд
- Осол, эрсдлийн менежментийн төлөвлөгөөний хүрээнд
- Хог хаягдлын менежментийн хүрээнд
- Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн хүрээнд

**СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ХҮРЭЭНД:**

2018 онд батлагдсан 10 аймгийн төвийн дулаан хангамжийг сайжруулах төслийн техник эдийн засгийн үндэслэл, байгаль орчны төлөв байдлын үнэлгээ, ерөнхий үнэлгээний дүгнэлтэд тулгуурлан байгаль орчны бүрдэл хэсгүүд бүрт тодорхойлсон сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөг хэрэгжүүлэх хугацаа, үндэслэл, баримтлан ажиллах дүрэм, стандартууд, зардлын хамт оруулсныг мөрдөж ажилласан.

**БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХҮРЭЭНД:**

Газрын гадарга, хэвлийд нөлөөлөх сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр				
Авч хэрэгжүүлэх арга хэмжээ	Авч хэрэгжүүлсэн ажлууд	Хугацаа	Зарцуулсан зардал	Хариуцан ажилласан
Дулааны станцын барилгын ажилд ашиглаж байгаа бараа материал, тоног төхөөрөмжийн сав, баглаа, боодол, материалын ашиглахгүй болсон хэсэг, ажиллагсадын ахуйн гаралтай хол хаягдлаар газрын гадарга бохирдож болзошгүй.	Барилгын талбайд хог хаягдал хадгалах түр хогийн цэг байгуулсан. Хог хаягдлыг зориулалтын тээврийн хэрэгслээр төвлөрсөн хогийн цэгт хүргэж хаяж байна.	Төслийн хугацаанд	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний төсөвт багтсан	ХАБЭАБО алба
Барилгын ажлын үед ашиглаж байгаа тээврийн хэрэгслээс тос, шатахуун асгарч газрын гадарга, хэвлийг бохирдуулж болзошгүй.	Төслийн талбайд зогсоол байгуулж тээврийн хэрэгслийг байрлуулж байна. Төслийн талбайд автомашины засвар үйлчилгээ хийхийг хориглосон. Хэрэв ШТМ асгарсан тохиолдолд саармагжуулах арга хэмжээг хурдан шуурхай авч хэрэгжүүлнэ.	Төслийн хугацаанд	Үйл ажиллагааны зардал	ХАБЭАБО алба
Дулааны станц, дулаан дамжуулах шугам болон дулаан дамжуулах төвүүдийг барих явцад нийт 2.33 га талбайгаас нийт 0.4 тн ялзмагийн нөөц бүхий 3495 м <sup>3</sup> үржил шимт хөрс хуулагдаж, эвдэрнэ.	Барилгын ажил эхлэхийн өмнө хуулж авсан шимт хөрсийг овоолгын талбайд хадгалан, нөхөн сэргээлтийн ажилд эргүүлэн ашиглахаар хадгалж байна.	Төслийн хугацаанд	Үйл ажиллагааны зардал	ХАБЭАБО алба

Барилгажилтын үе: Жижиг хөхтөн амьтад, тэдгээрийн нүх, оромж нөлөөлөлд өртөж болзошгүй.	Барилгажилтын явцад амьтад устахаас урьдчилан сэргийлж, газар хөндөлтийн өмнө амьтад өртөх эсэхийг шалгах, амьтдыг эрсдэх орчноос үргээж холдуулах ажлыг хийсэн.		Үйл ажиллагааны зардал	ХАБЭАБО алба
<b>Дүн</b>				

### ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХҮРЭЭНД:

Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний хүрээнд				
Авч хэрэгжүүлэх арга хэмжээ	Авч хэрэгжүүлсэн ажлууд	Хугацаа	Зарцуулсан зардал	Хариуцан ажилласан
Ахуйн хатуу хог хаягдлаар бохирдох	Хог хаягдлыг ангилан ялгаж, шаардлага хангасан хогийн цэг байгуулан түр хадгалж байна.	Төслийн хугацаанд		-ХАБЭАБО алба
Ахуйн хог хаягдлыг тогтоосон хугацаанд нь тээвэрлүүлэх	Сүхбаатар аймгийн тохижилт үйлчилгээний газартай байгуулсан хог хаягдал тээвэрлэх гэрээ байгуулан ажиллаж байна	7 хоног бүр	315.000	Сүхбаатар аймгийн тохижилт үйлчилгээ ОНӨААТҮГ -ХАБЭАБО алба
Газрын доорх усны чанар нөлөөлж болзошгүй хөрс бохирдуулахгүй байх,	Хэрэглээнээс гарсан бохир усыг ДӨРӨЛЖ ОНӨААТҮГ газартай гэрээ байгуулж татан зайлуулж байна,	7 хоног бүр	2.648.492	-Сүхбаатар аймгийн ДӨРӨЛЖ ОНӨААТҮГ -ХАБЭАБО алба
<b>Дүн</b>			<b>2.963.492</b>	

### **НӨХӨН СЭРГЭЭЛТ, ТОХИЖУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХҮРЭЭНД;**

Төслийн хувьд барилга угсралтын ажил нийтдээ 25,6 сарын турш үргэлжлэн, ашиглалтад хүлээлгэн өгөхөөр төлөвлөсөн тул нөхөн сэргээлт, орчны тохижилттой холбоотой ажлуудыг 2023 оны байгаль орчны менежмент төлөвлөгөөнд тусгаагүй учраас нөхөн сэргээлт, орчны тохижилтийн ажил 2023 онд хийгдээгүй.

Барилгын ажлын явцад болон дууссаны дараа нөлөөлөлд өртсөн газрыг тэгшилж, дулааны станцын барилга хоорондын талбайг тохижуулах, хөрс хуулалтаас хадгалсан өнгөн хөрсөөр ургамал ургах нөхцөлийг бүрдүүлэх, нөхөн сэргээлт, орчны тохижуулалт болон явган хүний зам, автозамыг хатуу хучилттай болгох ажил хийгдэнэ.

### **НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХҮРЭЭНД;**

Судалгааны хүрээнд тус аймагт дулааны станцын төсөлтэй холбоотой нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох айл өрх, хувь хүн, аж ахуйн нэгж байхгүй болно.

Төслийг хэрэгжүүлэх хугацаанд аймаг, сум, аж ахуйн нэгж, иргэдийн зүгээс нүүлгэн шилжүүлэх шаардлага хүргүүлээгүй тул нүүлгэн шилжүүлэх үйл ажиллагаа гараагүй.

### **ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХҮРЭЭНД;**

Сүхбаатар аймгийн Баруун Урт хотод баригдах дулааны станцын төслийн үйл ажиллагаанд хамаарах талбай болон түүний орчмын нутагт нь түүх соёлын дурсгалд тооцож болохуйц газар, археологийн болон палеонтологийн олдвор одоогоор тохиолдоогүй.

Цаашид үйл ажиллагааны явцад түүх, соёлын дурсгалт зүйл илэрсэн үед “Монгол Улсын Үндсэн хууль”-ийн I бүлгийн 7-р зүйлд “Монголын ард түмний түүх, соёлын дурсгалт зүйл, шинжлэх ухаан, оюуны өв төрийн хамгаалалтад байна” гэж заасны дагуу түүх, соёлын өвийг эрэн сурвалжлах, бүртгэх, судалж шинжлэх, зэрэглэл тогтоох, үнэлэх, хадгалж хамгаалах, сурталчлах, сэргээн засварлах, өвлүүлэн уламжлуулахтай холбоотой үүрэг хариуцлагаа мөрдөж ажиллах нь зүйтэй гэсэн үүрэг хүлээн ажиллаж байна.

**ОСОЛ ЭРСДЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХҮРЭЭНД:**

Төслийн бүхий л үе шатанд учирч болзошгүй аюул, осол эрсдлүүдийг урьдчилан тодорхойлох, түүнээс урьдчилан сэргийлэх чиглэлээр анхаарч ажиллаж байна.

Авч хэрэгжүүлэх арга хэмжээ	Авч хэрэгжүүлсэн ажлууд	Хугацаа	Зарцуулсан зардал	Хариуцан ажилласан
Төслийн талбайд гал түймрээс сэргийлэх, боломжит бүх арга хэмжээг авах, Нийт ажилчдыг гал унтраах сургалтад хамруулах, Галын дохиолол, гал унтраагуур, гал унтраах анхан шатны багаж хэрэгслийг байрлуулах, Төслийн талбайд галын дохиолол, аюулын гарц байрлалыг заасан самбар байрлуулах, галын дохиолол, гал унтраах хэрэгслийн тэмдэг санамж байрлуулах,	Галын аюулгүй байдлыг хангаж MNS 5566:2020 стандартын дагуу <b>В</b> ангиллын галын хор, галын сарайг хийж байршуулсан. Мөн төслийн барилгын шаардлагатай газруудад галын хор байршуулсан. Галын аюулаас урьдчилан сэргийлэх, анхааруулах, санамж тэмдэг, самбаруудыг барилгын талбайд байрлуулсан.	Төслийн хугацаанд	2.616.000	ХАБЭАБО алба
Төслийн талбайд аюулгүй ажиллагааны бүх дүрэм журам болон аюултай бодистой холбоотой бусад бүх журмыг дагаж мөрдөх	Төслийн талбайд аюултай бодистой холбоотой бүх дүрэм журмыг мөрдөж, тэсэрч дэлбэрэх аюултай хийн баллонуудыг зориулалтын хадгалах саванд хийн аюулгүй байдлыг хангасан. Бусад бүх журмыг дагаж мөрдөн ажиллаж байна.	Төслийн хугацаанд	Үйл ажиллагааны зардал	ХАБЭАБО алба
Ажилтны эрүүл мэндийг хамгаалах, урьдчилан сэргийлэх, эрүүл мэндийн тандалт судалгаа хийх	Яаралтай үед ашиглах анхны тусламжийн хайрцагийг байршуулж, шаардлагатай эм, тариа бусад хэрэглэлүүдээр хангасан.	Төслийн хугацаанд	2.135.000	ХАБЭАБО алба
Автомашины осол	Автомашины осол гэмтэл гарахаас урьдчилан сэргийлж тээврийн хэрэгслийн авто зогсоол байгуулсан. Барилгын ажлын үед зорчих замыг засч замын хөдөлгөөний дүрмийн дагуу тэмдэг тэмдэглэгээ байрлуулсан.	Төслийн хугацаанд	Үйл ажиллагааны зардал	ХАБЭАБО алба

Ажиллагсдын эрүүл мэнд	Ажиллагсдыг хүнс болон хэрэглээний усны чанарт анхаарч эрүүл ахуйн шаардлага хангасан цэвэр усыг хэрэглэж байна.	Жилд 1 удаа	Орчны хяналт шинжилгээний зардалд багтсан	ХАБЭАБО алба
<b>Дүн</b>			<b>4.751.000</b>	

**ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭЭНД:**

“ МонЭнержи Корпораци ” ХХК-ийн Сүхбаатар аймгийн Баруун Урт хотод хэрэгжүүлж буй дулааны станц барьж ашиглах төслийн орчны хяналт, шинжилгээний хөтөлбөрийн хүрээнд 2023 оны БОМ-н төлөвлөгөөний дагуу хөрс, агаар, шинжилгээг жилд 1 удаа авч Сүхбаатар аймгийн УЦУОШ газрын лабораторт, ундны уснаас хагас жил тутам дээж авч итгэмжлэгдсэн лабораторт шинжлүүлж байнгын хяналт тавин ажиллаж байна.

<b>Газрын гадарга, хөрсөн бүрхэвчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах</b>				
<b>Авч хэрэгжүүлэх арга хэмжээ</b>	<b>Авч хэрэгжүүлсэн ажлууд</b>	<b>Хугацаа</b>	<b>Зарцуулсан зардал</b>	<b>Хариуцан ажилласан</b>
<b>Хөрс</b>				
Ерөнхий хими болон элементийн шинжилгээ	Сүхбаатар Аймгийн Ус цаг уур, орчны шинжилгээний газарт төслийн барилгын талбайн 2 цэгээс дээж авч хөрсний шинжилгээ хийлгэсэн.	2023/05 сард	200.000	Сүхбаатар аймгийн УЦУОШ Газар ХАБЭАБО
<b>Дүн</b>			<b>200.000</b>	
			төгрөг	



## БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ НИЙТ ЗАРДЛЫН ТАЙЛАН

№	Менежментийн төлөвлөгөөний зардлын агуулга	Зарцуулсан зардлын хэмжээ, мян.төг
1	Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний зардал	2.963.492
2	Осол эрсдлийн менежментийн төлөвлөгөөний зардал	4.751.000
3	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн зардал	200.000
<b>Нийт</b>		<b>7.914.492</b>

### ДҮГНЭЛТ

Сүхбаатар аймгийн төвийн дулаан хангамжийг сайжруулах төсөл эхэлснээс хойш манайх 164 өдөр 1868 цаг аюул осолгүй, байгаль орчинд ээлтэй ажилласан байна. Энэ хугацаанд байгаль орчны эсрэг гарсан үл тохирол, зөрчилгүй ажилласан.

БОМ- н төлөвлөгөө боловсруулснаар хүн болон байгаль орчинд сөргөөр нөлөөлөх нөлөөллийг цаг алдалгүй хариу арга хэмжээ авч аюулгүй байдлыг ханган ажиллаж байна.

- Байгаль орчинд сөрөг нөлөөллийг бууруулах, эрүүл аюулгүй орчинд ажиллаж амьдрах орчныг бүрдүүлэхээр ажиллаж байна.

- Байгалийн давагдашгүй хүчин зүйл болон үер усны аюулаас урьдчилан сэргийлэх хяналтын арга хэмжээг хэрэгжүүлэх.

- Байгаль орчны тухай хууль тогтоомжыг мөрдүүлэн ажиллаж байна.

## Сүхбаатар аймгийн ДӨРӨЛЖ ОНӨААТҮГ тай хийсэн ус ашиглах гэрээ



"БАТЛАВ"

"МОН-ЭНЕРЖИ КОРПОРАЦИ" ХХК-ийн

МОНЕНЫ ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

CORPORATION

Д.АРИУНБААТАР



"БАТЛАВ"

"ДӨРӨЛЖ ОНӨААТҮГ-ийн

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

СҮГВИШИДЭЛГЭР

СҮХБААТАР АЙМАГ

## УС АШИГЛАЛТЫН ГЭРЭЭ

2023 оны 04 дүгээр сарын 11-ны өдөр

№ 001

Баруун-Урт сум

Нэг талаас "Дөрвөлж" ОНӨААТҮГ /цаашид "хангагч байгууллага" гэх/-ийг төлөөлж Хэрэглэгчдэд үйлчлэх албаны дарга Г.Энэрэл, нөгөө талаас "Мон-Энержи Корпораци" ХХК (РД:5455316) /цаашид "хэрэглэгч байгууллага" гэх/-ийг төлөөлж Угсралтын менежер Э.Лхагвасүрэн нар Монгол улсын Иргэний хууль, Хот суурины ус хангамж,ариутгах татуургын ашиглалтын тухай хууль, Усны тухай хууль болон холбогдох эрх зүйн актыг үндэслэн 2023 оны 04 дугаар сарын 11-ний өдрөөс 2024 оны 04 дугаар сарын 01-ний өдрийг хүртлэх хугацаанд энэхүү гэрээг хоёр тал харилцан тохиролцож байгуулав.

## Нэг. Ерөнхий зүйл

- 1.1 Энэхүү гэрээгээр хангагч байгууллага нь хэрэглэгчийг стандартын шаардлагад нийцсэн цэвэр усаар хангах, хэрэглээнээс гарсан бохир усыг татан зайлуулах, технологийн дагуу цэвэрлэх, хэрэглэгч байгууллага нь тохиролцсон төлбөр төлөх, түүнтэй холбогдох эрх, үүрэг, хариуцлагыг тогтооход оршино.
- 1.2 Хэрэглэгч байгууллага нь хангагч байгууллагатай уг гэрээг 12 сарын хугацаатай байгуулах бөгөөд зайлшгүй өөрчлөлт оруулах тохиолдолд хоёр тал албан ёсоор бичгээр харилцан тохиролцож байгуулна.
- 1.3 Хоёр тал аливаа маргаантай асуудлыг хамтран шийдвэрлэх бөгөөд тохиролцоонд хүрэхгүй бол шүүхээр шийдвэрлүүлнэ.
- 1.4 Гэрээнд 2 талын албан тушаалтнууд гарын үсэг зурж, тамга тэмдэг дарснаар хүчин төгөлдөр болно.

## Хоёр. Хангагч байгууллагын эрх үүрэг

- 2.1 Хангагч байгууллага нь хэрэглэгчийг стандартын шаардлагад нийцсэн цэвэр усаар хангах, хэрэглээнээс гарсан бохир усыг татан зайлуулах, технологийн дагуу цэвэрлэх, хэрэглэгчдээс гарсан санал хүсэлтийг хүлээн авч шуурхай барагдуулах арга хэмжээ авна.
- 2.2 Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хууль болон бусад норм, стандарт, дүрэм, зааврыг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллах үүрэгтэй.
- 2.3 Хангагч нь өөрийн эзэмшлийн шугам сүлжээ, тоног төхөөрөмжинд үзлэг шалгалт хийн зөрчлийг арилгуулах арга хэмжээ авна.
- 2.4 Хангагч хэрэглэгчтэй тогтсон тарифын дагуу ус, сувгийн системд төлбөртэйгээр засвар үйлчилгээ хийнэ.
- 2.5 Хангагч нь хэрэглэгч гэрээнд заасан үүргээ биелүүлээгүй тохиолдолд үндсэн болон дамжуулан хэрэглэгчийн ус, сувгийн үйлчилгээг хэсэгчилэн болон бүр мөсөн хязгаарлах арга хэмжээ авч болно.

## Сүхбаатар аймгийн ДӨРӨЛЖ ОНӨААТҮГ тай хийсэн ус ашиглах гэрээ

- 2.6 Хязгаарлалт хийхдээ хууль эрх зүйн актанд тавигдсан үндэслэлийг баримтлан урьдчилан мэдэгдэн хязгаарлалт хийх эрхтэй.
- 2.7 Хангагч байгууллага нь төлбөрийн нэхэмжлэлийг хэрэглэгчид сар бүрийн 20-ны дотор бичилтийн баримтын хамт хүргэж өгнө.
- 2.8 Төлбөр тооцооны хэмжих хэрэгсэл болон тооцоо хийсэн ажилтны буруугаас гарсан төлбөр тооцооны зөрүүг талууд харилцан тохиролцож дараа сарын тооцоонд оруулан нөхөн бичилт хийнэ.
- 2.9 Цэвэр, бохир усны үнэ тарифын өөрчлөлтийн талаар дараа жилийн төсвийн төсөл хийхээс өмнө хэрэглэгчдэд урьдчилан мэдэгдэх буюу хэвлэл мэдээллийн хэрэгслээр зарлана.
- 2.10 Үнэ тарифд орсон өөрчлөлтийн талаар хэрэглэгчид мэдэгдсэнээс хойш гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулаагүй нь уг өөрчлөлтийг мөрдөхөөс татгалзах үндэслэл болохгүй.

### Гурав. Хэрэглэгчийн эрх үүрэг

- 3.1 Хэрэглэгч нь стандартад нийцсэн цэвэр усаар хангуулах, хэрэглээнээс гарсан бохир усаа хангагчийн шугам сүлжээнд нийлүүлэх эрхтэй.
- 3.2 Хэрэглэгч өөрийн эзэмшилд байгаа шугам сүлжээ, тоног төхөөрөмжийн бүрэн бүтэн байдлыг хангах, засвар үйлчилгээ хийх ажлыг өөрийн хөрөнгөөр гүйцэтгэнэ.
- 3.3 Хэрэглэгч нь хангагчийг тоолуурын хэвийн ажиллагаа, лац, шугам сүлжээ, тоног төхөөрөмжид үзлэг шалгалт хийх, тоолуурын заалт авах зэрэг үйл ажиллагаагаа явуулах нөхцөл боломжоор хангах үүрэгтэй.
- 3.4 Тооцооны хэмжих хэрэгслийн эвдрэл гэмтэл нь хэрэглэгчээс шалтгаалаагүй, эсвэл тооцооны хэмжих хэрэгслийг шалгаж засварлах, баталгаажуулах зорилгоор шугамаас салгасан бол өмнөх 3 сард хэрэглэсэн цэвэр ус, татан зайлуулсан бохир усны хэмжээний дунджаар тооцно.
- 3.5 Хэрэглэгч нь гэрээнд заасан үүргээ биелүүлээгүй зөрчил гаргаж, энэ нь өөрийн болон бусдын эд хөрөнгө, материалд хохирол учруулсан бол тухайн хэрэглэгч хохиролыг 100% барагдуулна.
- 3.6 Хангагчийн нэхэмжлэлийн дагуу үйлчилгээний үнэ, төлбөрийг нэхэмжлэл авснаас хойш 5 хоногийн дотор бүрэн төлнө.
- 3.7 Хэрэглэгч нь 6 сараас дээш хугацаагаар үйл ажиллагаагаа зогсоох тохиолдолд ажлын 15 хоногийн өмнө бичгээр мэдэгдсэний үндсэн дээр усны суурь хураамжийн төлбөрөөс чөлөөлөгдөж болно.
- 3.8 Хэрэглэгч нь гэрээгээ цуцлах шаардлага гарсан тохиолдолд хангагч байгууллагад бичгээр ажлын 5 хоногийн өмнө урьдчилан мэдэгдэнэ.
- 3.9 Хангагч байгууллага нь үүргээ зохих ёсоор биелүүлээгүй тохиолдолд үйлчилгээний төлбөрийг бүрэн буюу зарим хэсгийг нь төлөхөөс татгалзах, хохирлоо нөхөн төлүүлэх нэхэмжилж болно.
- 3.10 Хэрэглэгчийн өмчлөлд байгаа шугам сүлжээ, тоног төхөөрөмжид бусад хэрэглэгчийг холбох тохиолдолд шаардагдах засвар үйлчилгээг тухайн байгууллага бүрэн хариуцна. Ашиглалтын явцад гарах шугам сүлжээний засвар үйлчилгээг өмчлөгч болон бусад хэрэглэгч нар гүйцэтгэх бөгөөд бололцоогүй бол хангагчаар хийлгэж гарсан зардлыг төлнө.
- 3.11 Өөрийн эзэмшлийн шугам сүлжээнд бусад хэрэглэгчийг холбосон тохиолдолд цэвэр ус түгээх, тэдгээрийн хэрэглээнээс гарсан бохир ус татан зайлуулах нөхцөлд хангагч

**Сүхбаатар аймгийн ДӨРӨЛЖ ОНӨААТҮГ тай хийсэн ус ашиглах гэрээ**

байгууллагаас үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдлын шимтгэлийг Зохицуулах зөвлөлийн баталсан хэмжээнд авна.

**Дөрөв. Төлбөр тооцоо, харилцан хүлээх хариуцлага**

- 4.1 Цэвэр усны үнэ нь м<sup>3</sup> нь 9250 /есөн мянга хоёр зуун тавь/ төгрөг байна. Энэ дүнд НӨАТ багтсан. Суурь хураамж 7600 /долоон мянга зургаан зуу/ төгрөг. Тус дүнд НӨАТ багтаагүй. Диаметр 25.
- 4.2 Хангагч нь хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр хэрэглэгчийн захиалгыг биелүүлээгүй тохиолдолд гарсан хохиролыг бүрэн хариуцна.
- 4.3 Хэрэглэгч нь ус хангамжийн байгууламж, ариутгах татуургын шугам сүлжээнд хангагчийн зөвшөөрөлгүйгээр холбосон, усны тоолуурын битүүмжлэл, байрлал, холболтыг дураараа өөрчилсөн тохиолдолд усны хэрэглээг хязгаарлаж, 3-н сарын нөхөн бичилт хийнэ.
- 4.4 Хэрэглэгч нь гэрээнд заасан хугацаанд төлбөрөө төлөөгүй тохиолдолд холбогдох хуулийн заалтын дагуу хэрэглээг хязгаарлах ба салган, залгалтын хөлсийг авна.
- 4.5 Хэрэглэгч нь ус, сувгийн үйлчилгээний төлбөрийг тоолуураар буюу нормоор тооцон нэхэмжилсний дагуу хугацаанд нь бүрэн төлөх ба хугацаа хэтрүүлбэл хэтэрсэн хоног тутам төлөгдөөгүй дүнгээс 0.3%-иар тооцон алданги төлнө, алдангийн хэмжээ үнийн дүнгийн 50%-аас хэтрэхгүй байна.
- 4.6 Хэрэглэгч нь захиалгат ус, сувгийн үйлчилгээний төлбөрийг бичилт хийснээс 5 хоногийн дотор багтаан төлөх ба хоёр тал сар бүрийн тооцоо нийлж баталгаажуулж байна.
- 4.7 Хэрэглэгчийн буруутай үйл ажиллагааны улмаас цэвэр ус алдах, бохир шингэн халиулсан тохиолдолд гарсан хохиролыг хэрэглэгч бүрэн хариуцна.
- 4.8 Төлбөрөө төлөөгүй тохиолдолд алдангитай дүнгээр шүүхийн байгууллагад нэхэмжлэл гаргах арга хэмжээ авч, хэрэглэгчийг төлбөрөө бүрэн барагдуулж дуустал цэвэр усаар хангахгүй болно.
- 4.9 Ажил үүргээ гүйцэтгэж байгаа ажилтанг хэл амаар доромжлох, нэр төрд нь халдах, айлган сүрдүүлсэн бол зохих хууль дүрмийн дагуу хариуцлага хүлээлгэх, хууль хяналтын байгууллагад өгч шийдвэрлүүлнэ.
- 4.10 Хэрэглэгчийн усны тоолуур нь баталгаагүй буюу эвдэрсэн, тоолуурын битүүмжлэлийг задалсан нь тогтоогдсон бол хэрэглэсэн цэвэр ус болон татан зайлуулсан бохир **усны хэмжээг өмнөх 3-н сарын дундаж хэмжээгээр** тооцно.

**Тав. Усны хэрэглээг тодорхойлох**

- 5.1 Ус хангамжийн хэмжээг тодорхойлохдоо МУ-д мөрдөж байгаа стандартын шаардлага хангасан, баталгаажуулсан, зориулалтын тоолуураар буюу задгайгаар /доогуур зурах/ тооцно.
- 5.2 Задгайгаар усны хэрэглээг тооцохдоо дэд бүтцийн болон Байгаль Орчны Сайдын баталсан усны хэрэглээний түр нормыг үндэслэн хэрэглэгчдийн онцлогыг харгалзан тодорхойлно.
- 5.3 Ариутгах татуургын үйлчилгээ буюу нийлүүлэх бохир шингэний хэмжээг тодорхойлохдоо тухайн хэрэглэгчийн үйл ажиллагааны онцлогыг харгалзан хэрэглэсэн цэвэр усны хэмжээгээр буюу тодорхой хувиар тогтоон тооцно.
- 5.4 Ус, хэрэглээ, нийлүүлэх бохир шингэний хэмжээ /захиалга/ өөрчлөгдсөн тохиолдолд хангагч байгууллагад бичгээр мэдэгдэж гэрээнд өөрчлөлт оруулна.

## Сүхбаатар аймгийн ДӨРӨЛЖ ОНӨААТҮГ тай хийсэн ус ашиглах гэрээ

- 5.5 Хангагч хэрэглэгч 2 талаас санал гаргаагүй, ус сувгийг үйлчилгээ, хэрэглэгчийн захиалгад өөрчлөлт ороогүй үйлчилгээ тасралтгүй явагдаж байгаа тохиолдолд энэхүү гэрээ нь 1 жилийн хугацаагаар сунгагдах бөгөөд уг хугацаанд хүчин төгөлдөр үйлчилнэ.
- 5.6 Дамжуулан хэрэглэгчийн тоолуурын заалтыг үндсэн хэрэглэгчийн тоолуурын заалтаас хасаж сарын хэрэглээг тогтооно.
- 5.7 Дамжуулан хэрэглэгч нь үндсэн хэрэглэгчийн зүгээс дамжуулан хэрэглэгчийн тоолуурт хяналт тавих бололцоогоор хангах үүрэг хүлээнэ.

### ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

#### ХЭРЭГЛЭГЧ БАЙГУУЛЛАГЫГ

##### ТӨЛӨӨЛЖ:

“Мон-Энержи Корпораци” ХХК-ийн

ЗСХ-ийн дарга

Ц.Өнөржаргал

Талбайн нярав

Гүйцэтгэлийн хяналт хариуцсан

мэргэжилтэн

Хуулийн мэргэжилтэн

М. Нарангарвуу

Г.Тойрууль

Ж.Нарангарвуу

Хаяг: Сүхбаатар аймаг, Баруун-Урт сум, 1-р баг дулааны станцын өргөтгөл

Утас: 94080498, 99041970

Цахим шуудан: [ariuk@monenergy.mn](mailto:ariuk@monenergy.mn)

#### ХАНГАГЧ БАЙГУУЛЛАГЫГ ТӨЛӨӨЛЖ:

“Дөрвөлж” ОНӨААТҮГ-ийн

Ерөнхий инженер, дэд захирал

Ч.Алдарбат

Хэрэглэгчдэд үйлчлэх албаны дарга

Г.Энэрэл

Хаяг: Сүхбаатар аймаг, Баруун-Урт сум, 3-р

баг, МСҮТ-ийн зүүн талд

Утас: 77710000, 99512345, 99510003

Цахим шуудан: [dorvolj@yahoo.com](mailto:dorvolj@yahoo.com)

#### Хангагч байгууллагын харилцах данс:

Хаан банк 5630001670

Хас банк 5000166202

Төрийн банк 270000064511

Голомт банк 5900000060

## Сүхбаатар тохижилт үйлчилгээ ОНӨААТҮГ тай хийсэн хог хаягдал тээвэрлэх гэрээ

"БАТЛАВ"  
"СҮХБААТАР ТОХИЖИЛТ ҮЙЛЧИЛГЭЭ"  
ОНӨААТҮГ-ЫН ДАРГА

Х.БААТАРСҮХ

"БАТЛАВ"  
"МОН-ЭНЕРЖИ КОРПОРАЦИ" ХХК-ИЙН  
СОГҮЙ ЦЭТЭХ ЗАХИРАЛ

Д.АРИУНБААТАР

## ХОГ ХАЯГДАЛ ТЭЭВЭРЛЭХ ГЭРЭЭ

2023 оны 04-р сарын 12-ны өдөр

№

Баруун-Урт сум

Нэг талаас "Сүхбаатар аймгийн тохижилт үйлчилгээ" ОНӨААТҮГ /РД: 3675114/ (цаашид "Үйлчлэгч" гэх)-ыг төлөөлж Борлуулалтын байцаагч ажилтай Г.Батцэцэг нөгөө талаас "Мон-Энержи Корпораци" ХХК /РД:5455316/ (цаашид "Үйлчлүүлэгч" гэх)-ийг Угсралтын менежер ажилтай Э.Лхагвасүрэн, бид 2023 оны 04 дугаар сарын 12-ны өдрөөс эхлэн 2024 оны 04 дугаар сарын 12-ний өдөр хүртэл 1 жилийн хугацаатай энэхүү гэрээг хоёр тал харилцан тохиролцож байгуулав.

## Нэг. Ерөнхий зүйл

- 1.1 Энэхүү гэрээний зорилго нь Үйлчлэгч тал нь хүний эрүүл мэнд хүрээлэн буй орчинд үзүүлэх хортой нөлөөллийг арилгах, түүнээс урьдчилан сэргийлэх зорилгоор Үйлчлүүлэгчийн ахуйн болон хуурай хог хаягдлыг цуглуулан/ачих/, тээвэрлэн, зайлуулах /цаашид "Үйлчилгээ" гэх /, Үйлчлүүлэгч нь үйлчилгээний төлбөрийг төлөх, түүнтэй холбогдон гарах харилцааг зохицуулахад оршино.

## Хоёр. Үйлчлэгч байгууллагын эрх үүрэг

- 2.1 Хог хаягдлыг тээвэрлэх аюулгүй ажиллагааны шаардлагыг хангасан битүүмжилсэн тээврийн хэрэгслээр тээвэрлэнэ.
- 2.2 Үйлчлүүлэгчийн хог хаягдлыг Хавсралт №1-д заасны дагуу 7 хоногт 2 удаа буюу Мягмар, Баасан гарагт тус тус тогтмол цагт авч, төвлөрсөн хогийг цэгт хаяна.
- 2.3 Хуурай хог хаягдлыг тээвэрлэх 2.2-т заасан хугацаанд өөрчлөлт орвол үйлчлэгчид 3 хоногийн өмнө мэдэгдэнэ.
- 2.4 Энэхүү гэрээний 2.2-т заасан хугацааг зөрчиж аж ахуй нэгжийн хуурай хаягдлыг хуримтлуулж байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлсэн тохиолдолд хариуцлага хүлээнэ.
- 2.5 Үйлчлэгч нь үйлчилгээний сарын төлбөрийн нэхэмжлэлийг тухайн сарын 25-ны өдрөөс 30-ны өдрийн хооронд цахим нэхэмжлэхийн хамт илгээнэ.

## Гурав. Үйлчлүүлэгчийн эрх үүрэг

- 3.1 Хог хаягдлын тухай хуулийн 10.2.2, 10.2.3, 10.2.6, 10.2.7, 10.2.10 дугаар зүйлийг мөрдлөг болгон ажиллана.
- 3.2 Үүсгэсэн хог хаягдлыг үйлчлүүлэгч хог хаягдлын тухай хуулийн 15 дугаар зүйлд заасан стандартын хогийн саванд түр ангилан хадгалж графикийн дагуу тээвэрлүүлдэг байх, тэмдэглэл хөтлөх, гарын үсэг зуруулж баталгаажуулах.
- 3.3 Хог хаягдлын талаарх дүрэм журам шаардлагыг хангаж ажиллана.
- 3.4 Хуульд заасан бусад эрхийг эдэлнэ.
- 3.5 Хог хаягдлын тухай хуулийн 41.1, 41.2 дахь заалтыг үндэслэн хог хаягдлын үйлчилгээний хураамж төлнө. Сүхбаатар аймгийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2021 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн 10 дугаар тогтоолоор батлагдсан хог хаягдлын үйлчилгээний хураамж **1 сарын 70000 /Далан мянга/ төгрөг** төлнө. Сар бүр Үйлчлэгч талын нэхэмжлэл, цахим нэхэмжлэлийг хүлээн авснаас хойш төлбөрийг ажлын 3 хоногт багтаан Үйлчлэгчийн **Хаан банкны 5630004547** тоот дансанд төлнө.
- 3.6 Хэрэв үйлчлэгч тал гэрээгээр хүлээсэн үүргээ ноцтой зөрчсөн бөгөөд үүрэг гүйцэтгэх нэмэлт хугацаа тогтоосон боловч үр дүн гараагүй бол гэрээг цуцалж, учирсан хохирлоо нөхөн төлүүлэхээр шаардах эрхтэй.

## Сүхбаатар тохижилт үйлчилгээ ОНӨААТҮГ тай хийсэн хог хаягдал тээвэрлэх гэрээ

## Дөрөв. Хариуцлага

- 4.1 Энэхүү гэрээгээр хүлээсэн үүргээ гүйцэтгээгүй эсвэл зохих ёсоор гүйцэтгээгүй тал нь талдаа Монгол улсын Иргэний хуулийн 232 дугаар зүйлд заасны дагуу алданги төлнө.
- 4.2 Хог хаягдлын тухай хуулийн 43.1, 43.2 дахь заалтуудаар зохицуулна. Жич: Маргааныг хуулийн дагуу шийдвэрлэнэ.

## Тав. Гэрээний хугацаа

- 5.1 Гэрээ байгуулсан өдрөөс эхлэн 1 жилийн хугацаатай. Талуудын аль нэг нь санал гаргаагүй тохиолдолд гэрээг цаашид 1 жилээр сунгагдсанд тооцно.
- 5.2 Гэрээнд заасан үйлчилгээг Үйлчлэгч тал нь гэрээний хугацаанд 7 хоногт 2 удаа буюу Мянгар, Баасан гарагт тус тус үзүүлнэ.

## Зургаа. Бусад

- 6.1 Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах бол талууд харилцан тохиролцож, бичгээр үйлдэж, баталгаажуулснаар нэмэлт, өөрчлөлт оруулах ба гэрээний биелэлтийг сар, улирал, хагас бүтэн жилээр дүгнэж ажиллана.
- 6.2 Гэрээний талууд энэхүү гэрээ байгуулсантай холбогдон олж мэдсэн бүхий л мэдээллийн нууцлалыг хадгална.
- 6.3 Энэхүү гэрээг 2 хувь үйлдэж гэрээнд харилцан гарын үсэг зуран тамга тэмдэг дарснаар хүчин төгөлдөр болж мөрдөгдөж эхэлнэ.

## Гэрээ байгуулсан:

## Үйлчлэгчийг төлөөлж:

Сүхбаатар тохижилт үйлчилгээ  
ОНӨААТҮГ-н борлуулалтын байцаагч

*Г.Батцэцэг* Г.Батцэцэг

Утас: 70518637, 99137300

## Үйлчлүүлэгчийг төлөөлж:

"Мон-Энержи Корпораци" ХХК-ийн  
ЗСХ-ийн дарга

Талбайн нярав *Ц.Өнөржаргал*

Гүйцэтгэлийн хяналт хариуцсан мэргэжилтэн *Х.Цэнд-Арслан*  
Г.Тойрууль

Хуулийн мэргэжилтэн

*Ж.Нарангарзуу* Ж.Нарангарзуу  
Хаяг: Сүхбаатар аймаг, Баруун-Урт сум, 1-р баг  
дулааны станцын өргөтгөл  
Утас: 94080498, 99041970

Цахим шуудан: [ariuk@monenergy.mn](mailto:ariuk@monenergy.mn)

## Хөрсний шинжилгээ



“НАРТ ШУУН КОНСАЛТИНГ” ХХК  
ХӨРСНИЙ ИТГЭМЖЛЭГДСЭН ЛАБОРАТОРИ



Монгол улс, Улаанбаатар хот, Сонгино Хайрхан  
дүүрэг, 19-р хороо, ҮЭГ, ЗК 17024 Ш/х 10  
Утас: (976)-99176123, 99231836

E-mail: nartconsulting@gmail.com

№ 23/05-11/1

Захиалагч: “Мон Энержи Корпораци” ХХК

Дээж авсан цэг: Сүхбаатар аймаг, Дулааны цахилгаан станц

Сорьц авсан огноо: 2023 оны 05 сар 08 өдөр

Шинжилгээ хийсэн огноо: 05 сарын 11

Харилцах утас:

1. ХӨРСНИЙ ХИМИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

№	Дээж авсан гүн, см	pH	Давс, %	ЦДЧ, ds/m	Ялзмаг, %	CaCO <sub>3</sub> , %	NO <sub>3</sub> , мг/100г	Солилцох сууриуд, мг-эquiv/100 г		Шим тэжээлийн элементүүд, мг/100г	
								Ca <sup>+2</sup>	Mg <sup>+2</sup>	P <sub>2</sub> O <sub>5</sub>	K <sub>2</sub> O
Цахилгаан байгууламж											
1	0-20	8.52	0.033	0.082	2.11	0.0	0.31	16	4	6.8	9
Бутлуурын барилга											
2	0-20	8.44	0.026	0.064	1.43	0.0	0.18	12	8	9.5	14

2. ХӨРСНИЙ МЕХАНИК БҮРЭЛДЭХҮҮН

№	Дээж авсан гүн, см	Механик ширхэгүүд, % ширхэгийн хэмжээ, мм						
		1-0.25	0.25-0.05	0.05-0.01	0.01-0.005	0.005-0.001	<0.001	<0.01
Цахилгаан байгууламж								
1	0-20	46.7	26.5	7.4	5.2	5.5	8.7	19.4
Бутлуурын барилга								
2	0-20	34.9	45.7	4.2	5.4	5.7	4.1	15.2

3. ХӨРСНИЙ ХҮНД МЕТАЛЛЫН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Дээж авсан газар, Газар зүйн байршил	Дээж авсан гүн, см	Cr	Pb	Cd	Zn	Cu	Ni
		мг/кг	мг/кг	мг/кг	мг/кг	мг/кг	мг/кг
Цахилгаан байгууламж	0-20	60.9	31.3	0.0	23.8	18.9	12.5
Бутлуурын барилга	0-20	59.2	27.1	0.0	17.6	17.3	9.5
Зөвшөөрөгдөх дээд хэмжээ, MNS 5850:2019							
Элсэрхэг хөрс		60	50	1	100	60	60
Шавранцар хөрс		100	70	1.5	150	80	100
Шаварлаг хөрс		150	100	3	300	100	150

\*Харгалзах түвшин \* Жич: Энэхүү шинжилгээний хариу нь тухайн цэгийн дээжэнд хамаарна

ЗАДЛАН ШИНЖИЛГЭЭНИЙ АРГЫН СТАНДАРТУУД: (Хөрсний агрохимийн үзүүлэлтүүд MNS3310:1991, MNS ISO10390, хөрсний механик бүрэлдэхүүн MNS6824:2020, Хүнд металлуудыг -хаан дарсанд атом шингээлтийн спектрометрээр MNS ISO 11466:2007)

ЗАДЛАН ШИНЖИЛГЭЭГ ГҮЙЦЭТГЭСЭН: Х.УУТАНЦЭЦЭГ, Д.ЭНХЧИМЭГ  
ХЯНАСАН ЛАБОРАТОРИЙН ЭРХЛЭГЧ: Г.СОЛОНГО Ph.D, Дэд профессор





## ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

1	Сүхбаатар төслийн барилгын талбайн 2 цэгээс дээж авч хөрсний шинжилгээ хийлгэсэн.	
2	Төслийн барилгын талбайн 2 цэгээс дээж авч хөрсний шинжилгээ хийлгэсэн.	
3	Ахуйн хатуу хог хаягдлыг байршуулах тусгай хогийн цэг байршуулсан.	
4	Галын аюулгүй байдлыг хангаж MNS 5566:2020 стандартын дагуу В ангиллын галын сарайг хийж байршуулсан.	

5	Барилгын суурийн ухсан нүхийг хатуу хаалт хашилт болон тороор хааж хяналтын арга хэмжээ авсан.
6	Төслийн талбайн эргэн тойронд анхааруулах тэмдэг санамж байрлуулж хог хаягдлыг цэвэрлэж байна.
7	Хог хаягдлыг зориулалтын дагуу тээвэрлэн хаяж байна. Гэрээ хийгдсэн.
8	Барилгын ажилд ашиглаж байгаа техникийг хуваарийн дагуу үзлэгт оруулж, тээврийн хэрэгслийн бүрэн бүтэн байдлыг хангуулан ажиллаж байна.